




2025 01-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ИНФЛЯЦ ОНЫ ЭЦЭСТ 9%-Д ХҮРЧ ИДЭВХЖЛЭЭ

- Монгол банкнаас энэ онд бодлогын хүүг тус бүр 1 нэгж хувиар 3 удаа буулгаж 10%-д хүргээд байгаа билээ. Харин мөнгөний бодлогын хорооны 1 сарын 14-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 10%-д хэвээр үлдээж харин төгрөг болон валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тус бүр 2%-иар нэмэгдүүлж харгалзан 13% болон 18%-д хүргээд байна.
- Ийнхүү инфляц төв банкны зорилтын дээд хязгаарыг давснаар энэ онд дахин бодлогын хүү буурах орон зай бага байгааг илтгэж байна. Инфляц оны эцэст ийнхүү өсөж эрчимжихэд оны эхнээс эхлэн тасралтгүй өссөн импортын өсөлт болон 11 сараас нэмэгдүүлсэн цахилгаан, дулааны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.
- Энэ онд Эрдэнэс Тавантолгойн ногдол ашиг тараагдах, төсвийн тэлэлт үргэлжлэн өсөхтэй холбоотойгоор инфляц оны эцэст өсөх хүлээлттэй байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ БАРАА ЭРГЭЛТ ОНЫ ЭЦЭСТ 27.4 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ӨМНӨХ ОНООС 12%-ИАР ӨСЛӨӨ

- Нийт экспорт 2024 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс ердөө 4%-иар өслөө. Нийт экспорт өсөхөд зэсийн экспортын орлого 26%-иар өсөж 3.3 тэрбум ам.долларт, алтны экспорт 22%-иар өсөж 899 сая долларт хүрсэн, төмрийн хүдрийн экспорт 34%-иар нэмэгдэж 598 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөллөө.
- Нүүрсний экспортын биет хэмжээ оны 79.5 сая тоннд хүрч өмнөх оноос 19.2%-иар өссөн ч нийт нүүрсний экспортын орлого 8.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 3%-иар буурсан байна. Нүүрсний хилийн үнэ оны эцэст тонн тутамд 88\$-т хүрч өмнөх оны мөн үеэс 26%-иар буурсан нь нүүрсний экспортын орлого буурахад голлон нөлөөллөө.
- Нийт импорт оны эцэст 11.6 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 26%-иар өслөө. Нийт импорт өсөхөд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 30%-иар өсөж 4.9 тэрбум ам.долларт, хэрэглээний бүтээгдэхүүн 32%-иар өсөж 3.5 тэрбум ам.долларт хүрсэн нь голлон нөлөөллөө.
- Улмаар худалдааны тэнцэл оны эцэст 4.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1.7 тэрбум ам.доллараар буюу 30%-иар буурлаа.

ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ 5.5 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЛЭЭ

- 2024 оны байдлаар гадаад валютын албан нөөц 5.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 11.8%-иар өслөө. Хэдийгээр гадаад валютын нөөц түүхэн дээд түвшинд хүрч өссөн ч импортын өсөлтийн нөлөөгөөр 5.3 сарын импортын хэрэглээг хангах түвшинд байна.
- Олон улсны зах зээл дээр гаргасан бондуудын нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 37.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Харин төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 1.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1 тэрбум ам.доллараар муудсан байна. Ирэх оны төсвийн тэлэлтээр дамжин импорт дахин өсөж, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж улмаар гадаад валютын нөөц буурах эрсдэлтэй хэвээр байна.
- 2026 оноос эхлэн засгийн газрын томоохон бондуудын төлөлт хийгдэх тул гадаад валютын нөөцийг зөв зарцуулж, хуримтлуулах нь чухал байна.

УЛСЫН ТӨСӨВ 776 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРЛАА

- 2024 оны гүйцэтгэлээр төсвийн зардал 30.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 34.9%-иар буюу 8 их наяд төгрөгөөр өслөө. Харин төсвийн орлого 29.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 27%-иар өссөн байна. Улмаар төсвийн тэнцэл 776 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Төсвийн орлого өсөхөд орлогын албан татвар 57.5%-иар өсөж 8.9 их наяд төгрөгт, НД-ийн орлого 19%-иар өсөж 4.7 их наяд төгрөгт хүрсэн нь голлон нөлөөллөө.
- Төсвийн зардлын 26.4% нь хөрөнгийн зардал байгаа бол үлдсэн 73.6% нь урсгал зардал байна. Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж 17.1%, засгийн газрын урсгал шилжүүлэг 7.5%, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж 7.7%-ийг тус бүр бүрдүүлж байна. Энэ оны 1 сарын 1-ээс төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэрийг тус бүр 6%-иар нэмэгдүүлж байгаа бөгөөд төсвийн зардлыг 33.5 их наяд төгрөг хүрэхээр баталсан.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q3	2024Q2	2023Q3	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	22,828	14,407	21,751	5.00%
Ажилгүйдлийн түвшин	%	6.1	5.8	5.3	15.1%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,480	2,465	2,009	23.4%
Гадаад өр	сая ам.доллар	35,639	34,867	33,246	7.2%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M12	2024M11	2023M12	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	15,783	14,596	15,187	3.9%
Зэс	сая ам.доллар	3,319	2,937	2,626	26.4%
Нүүрс	сая ам.доллар	8,535	8,053	8,764	-2.6%
Нийт импорт	сая ам.доллар	11,612	10,567	9,250	25.5%
Хэрэглээ	сая ам.доллар	3,546	3,213	2,691	31.8%
Түүхий эд	сая ам.доллар	933	860	852	9.5%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	4,955	4,540	3,820	29.7%
Шатахуун	сая ам.доллар	2,162	1,939	1,869	15.7%
Тэнцэл	сая ам.доллар	4,171	4,029	5,937	-29.7%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	8,909	9,076	8,407	6.0%
Нүүрс	\$/тонн	140.2	150.6	149.4	-6.2%
Газрын тос	\$/баррель	73.23	73.5	77.54	-5.6%
Алт	\$/трой унц	2,640	2,652	2,035	29.7%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	-777	1,373	786	-198.8%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	29,589	26,077	23,295	27.0%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	30,366	24,704	22,509	34.9%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M12	2024M11	2023M12	
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	43,334	41,507	37,624	15.2%
ХҮИ (C2020)	индекс	152.2	150.1	139.5	9.1%
Бодлогын хүү	%	10.00%	10.00%	13.00%	-23.1%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,420	3,418	3,411	0.3%
Төгрөгийн хадгаламж	%	12.87%	12.93%	12.38%	4.0%
Валютын хадгаламж	%	4.14%	3.25%	4.20%	-1.4%
Төгрөгийн зээл	%	16.91%	17.00%	16.74%	1.0%
Валютын зээл	%	9.60%	10.18%	10.47%	-8.3%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	5,510	4,964	4,921	12.0%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН


■ Ажилгүйдлийн түвшин

— Дундаж нэрлэсэн цалин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Source: National Statistics office

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.